

Mongolian A: literature – Standard level – Paper 1
Mongol A: littérature – Niveau moyen – Épreuve 1
Mongol A: literatura – Nivel medio – Prueba 1

Wednesday 10 May 2017 (afternoon)

Mercredi 10 mai 2017 (après-midi)

Miércoles 10 de mayo de 2017 (tarde)

1 hour 30 minutes / 1 heure 30 minutes / 1 hora 30 minutos

Instructions to candidates

- Do not open this examination paper until instructed to do so.
- Write a guided literary analysis on one passage only. In your answer you must address both of the guiding questions provided.
- The maximum mark for this examination paper is **[20 marks]**.

Instructions destinées aux candidats

- N'ouvrez pas cette épreuve avant d'y être autorisé(e).
- Rédigez une analyse littéraire dirigée d'un seul des passages. Les deux questions d'orientation fournies doivent être traitées dans votre réponse.
- Le nombre maximum de points pour cette épreuve d'examen est de **[20 points]**.

Instrucciones para los alumnos

- No abra esta prueba hasta que se lo autoricen.
- Escriba un análisis literario guiado sobre un solo pasaje. Debe abordar las dos preguntas de orientación en su respuesta.
- La puntuación máxima para esta prueba de examen es **[20 puntos]**.

Доорх хоёр зохиолоос зөвхөн **нэгийг** нь сонгож, хөтөч хоёр асуултын дагуу уран зохиолын талаас задлан тайлбарлаж бич.

1.

Эрт Чин улсын нэгэн хийдэд нэгэн их лам тэргүүлэн тэр орны тахилын орон болж суун бүлгээ. Тэр ламын суух харшид хав, муур, хулгана гурван амьтан байдаг ажгуу. Нэгэн өдөр тэр хулгана бээр ламын нэгэн уутыг цоолон амандаа будаа дүүргэн үмхэж явтал муур бээр хулганыг шүүрч бариад ийн өгүүлэв: “Манай гурван амьтан гэр орон ба өв

5 хувьгүй боловч гагцхүү ламын элдэв эрдэнэсээр үүдсэн үзэсгэлэнт сайхан харшид халуун хүйтэн цагийг өнгөрүүлэн аливаа сайхан амттай мах, будаа, гурил тэргүүтнийг идэж дураар цэнгэн жаргаж суун бөгөөтөл, ачийг яахан хариульъя хэмээн санахгүй. Харин ламын санд хураасан магнаг торгон чимэг ба хувцас, эд агуурс, идээ будааны зүйлийг

10 дэмий дураар хивж сүйтгэн хулгаж¹ хор хомс болгох нь зохих уу? Чамд өөрийн хэмээх хот балгас ба ураг садан буй болбоос бас ч нэгэн зүй мөн. Тэр нь үгүй, ганц бие бөгөөд юунд дэмий чингэж ховдогломуй? Энэ бие мөнх бус бөгөөд хэзээ үхэх магадгүй тул, эд идээг хэдий их хураавч эцэст авч одох журамгүй, эгнэгт хоосон сүнс ганцаар одмуй заа. Үхтэл амь зууж өдөр шөнийг өнгөрүүлбээс барав” хэмээхэд хулгана өгүүллүүн: “Манай гурван амьтан ламын буянд шүтэж амьдармуй хэмээх нь үнэн. Бид гурав урьд үйлдсэн

15 муу үйлийн эрхээр адгуусны төрлийг авч амьтан хэмээх нэрийг олжээ. Манай бурхан лам болбоос амьтан бүхний аврал итгэл мөн бөгөөтөл, цөмийг нэгэн адил өршөөвөл зохино биз. Юунд адил адгуус бөгөөтөл манай дотроос хавыг илүү үзмүй. Гэх ч байтугай хав та хоёрт өдөр тутам сайн идэш өгмүй. Над огт өгөхгүй нь даанч хөөрхий. Амьтан бүхний амьдрал гагцхүү идээ будааны шим буюу. Амьтан болон төрөгсөд амиа хайрлах нь

20 нэгэн адил биш үү. Амьтан бүхний аврал лам мөн бөгөөд юунд өчүүхэн хулгана намайг огоормуй? гэх төдийгүй, муур чамайг тэжээсэн санаа болбоос чамд тэжээл хувь үгүй хэмээн энэрч тэжээсэн нь бус, хураасан эдээ хамгаалуулж, хулгана намайг хөнөөлгөх учирт тэжээсэн хэрэг болой. Хувьд заяасан буянгүй, худалдаж авах өртөггүй хулгана би хулгаж амьдрахаас бус өөр яахан амьдармуй? Өөрийн амийг өөрөө тасалбаас бусдын

25 амийг тасалсны адил нүгэл хураамуй хэмээн лам бээр шавь нартаа номлохыг сонсов. Би хулгахыг тэвчвээс, өлбөрч үхэх нь магад буй. Би бас өөрөө амь тасалсны үйл хураахгүй буюу? Зүү мэт хурц шүд хумстай, зүймэл хөдөс мэт эрээн дээлтэй, шөлний тос мэт ногоон нүдтэй, зальхай муур чи харин ичгүүргүй энэ нас мөнх бус, хэзээ үхэх магадгүй, өдий хоногийг өнгөрүүлбээс барав, зөөн хураах юуны хэрэг хэмээх буюу? Харин чи ламын

30 сангаас хувьтай, өдөр бүр нэгэн аяга будаа идэх бөгөөд юунд шөнө тутам илүү идэш олохыг хичээж өчүүхэн хулгана намайг гэтэж айлгамуй. Гэр оронгүй амьтан гэдсэндээ идвээс барав хэмээсэн үг багшийн чинь номлолд буй биш үү. Явдал номлол тохирохгүй энэ учир юун гайхалтай. Буян нүглийг мэдэх номлох хялбар буй заа. Харин цээрлэн үйлдэх нь хэцүү амуй. Асар хурц хумсаар арьс махыг минь нэвт шувт хатган атгаж, алт мэт амийг алдахуйд хүрч бүхийд аяа хөөрхий нөхөр чамд энэрэх сэтгэл төрөхгүй юү?

35 Ухамсаргүй чамаас илүү хүчтэн, уран мэхтэй чиний адил гэтэж ирээд чамайг энэ мэт атган зовоох болхул² яалтай байна? Төрөлхтөн бүхэн төрөх өтлөх өвдөх үхэхийн дөрвөн далайн дотор амь биеэ хайрлах нь нэгэн адил болой. Өөрийн биеэс үлгэр авч өчүүхэн миний амийг хэлтрүүлбээс болох болов уу? гэхээс гадна, буян нүглийн үр бодьтой

40 боловсормуй хэмээн бурхан багшийн гэгээн номлосон бөгөөд өөрөө мэдэж хэлсээр байж юунд ийм өөдгүй үйл үйлдмүй” хэмээн өгүүлбээс муурын уур нь гал мэт бадран хүрч хариу тэмцэн завдтал, тэдний дэргэд байсан хав ийн өгүүллүүн: “Саваагүй муу муур чи санааны дураар дэмий бүү явагтун. Савсаг чиний байдал төлөв барс лугаа адил төстэй боловч, баатар түүний сүр хүч чамд буй буюу? Сайн ламын санд нэгэн адил амь хорьж

45 бүхий атал, санамсаргүй хөөрхий өчүүхэн хулганыг юунд барьж зовоомуй?

Гэндэн мэйрэн, *Монголын уран зохиолын дээж бичиг зуун билиг оршивой* (1959)

- (a) Зохиолын энэ хэсэгт хүний зан араншинг хав нохой, муур, хулгана зэргээр төлөөлүүлэн хэрхэн дүрсэлсэн байна вэ?
- (б) Зохиолын энэ хэсэгт адилтгал гэх мэт уран дүрслэлийн аргыг хэрхэн хэрэглэсэн байна вэ?

¹ хулгаж: хулгайлж

² болхул: болбол

2.

Увш хаан үгээ үргэлжлүүлэн
Уригдсан зочиддоо хандаж
Атгаад зангидсан гар шиг
Цул байхыг эрхэмлэгтүн!
5 Араатны хаан арслан шиг
Цөстэй байхыг хичээгтүн!
Холын нүүдэлд зэхэн бэлдэж
Хураасан шагай шиг бөөгнөж
Товлосон өдрийг харзнан
10 Тогтон саатаж байгтун!
Цацсан шагай шиг түмнээс
Царцаа ч цочиж дэвхрэхгүй
Хураасан шагай шиг түмнээс
Хатгалдагч дайснууд эмээнэ.
15 Эвтэй байхдаа хүчтэй байсан
Эртний уламжлалаа санагтун!
Эв эе нэг байж гэмээн
Эзэнт улс манддаг гэж
Эзэн Чингис хааны хэлснийг
20 Эрэгцүүлэн сайтар бодогтун!
Өөрийн биеийг умартан байж
Өргөн олны төлөө зүтгэгтүн!
Биеийн хүчээр нэгийг дийлнэ
Билгийн хүчээр олныг дийлнэ
25 Эр биеийн хүчээр
Цөөхнийг дийлж болох ч
Эв эеийн хүчээр
Цөмийг дийлж болно.
Түүхэн их нүүдлийн замыг
30 Тодоор бичиж үлдээхэд
Хүн бүхэн дор бүрнээ
Хүчин зүтгэж оролцох учиртай
Нүүдэл хийх энэ их үйлс нь
Нийтэд хамааралтайг ухаарч
35 Наран мандах зүгийг бариад
Найдварын галаа унтраахгүй
Намайг дахаад* хөдөлцгөө! гэж
Уриалан дуудаж зарлиг буулгаад
Увш хаан сэнтийдээ заларлаа.

Е Амаржаргал, *Торгууд түмний түүхэн их нүүдэл* (2014)

- (a) Увш хааны дүр байдал болон үзэл бодлыг яаж дүрслэн үзүүлсэн байна вэ?
- (б) Эв нэгдэлтэй байхын чухлыг хэрхэн дүрсэлсэн байна вэ?

* дахаад: дагаад